



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/127

Хэрлэн сум

Пауэрлифтингийн тэмцээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Пауэрлифтингийн "Хүчний хаад" холбооны тэргүүн Б.Саранхүүгийн ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн аварга шалгаруулах Пауэрлифтингийн тэмцээнийг зохион байгуулах зардалд 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг түшиглэн биеийн тамираар хичээллэгсдийг нэмэгдүүлнэ" арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын...-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

Пауэрлифтингийн ААШ тэмцээний төсөв							
1	Медаль өргөмжлөл хийх зардал						
1.1	Медаль, өргөмжлөл	40	40	40	120	10000	1200000
2	Шүүгчдийн хөлс						
2.1	Ерөнхий шүүгч				1	50000	50000
2.2	Тайлбарлагч шүүгч				1	50000	50000
2.3	Талбайн шүүгч				1	50000	50000
2.4	Нарийн бичиг шүүгч				1	50000	50000
2.5	Шүүгч нарын хоолны зардал				4	25000	100000
2.6	Нийт						1,500,000